



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар

130

Хархорин сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 9.1, 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн цахим дуудлага худалдааг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхагвасүрэн (Засаг даргын орлогч)

Хөтлөгч: Ч.Баттулга (Газрын даамал)

Тэмдэглэл хөтлөгч: Э.Дэнсмаа (Газрын даамал)

2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах, газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

411000259